БАТЛАВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ГҮНЖДАГВА

ӨМНӨГОВЬ АЙМАГ ТАВАНТОЛГОЙ ХК

НҮҮРС АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ерөнхий зүйл:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багт орших Цагаан хад суурьшлын бүсэд байрлах Гаалийн хяналтын бүсийн зориулалт бүхий нүүрс ачилт, буулгалтын талбай худалдан авах, сонгон шалгаруулах.

Байршил: Өмнөговь аймаг, Ханбогд сум, Хайрхан баг

Талбайн хэмжээ: 20 га ба түүнээс дээш

Хүчин чадал: 1 сард ачиж буулгах хүчин чадал: 500,000 тонн ба түүнээс дээш

Гаалийн хяналтын бүсэд тавигдах шаардлага:

1. Гаалийн хяналтын бүс нь Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар зарлуулсан зөвшөөрөлтэй байх бөгөөд зөвшөөрөл дуусгавар болох хугацаа нь тендер зарласан хугацаанаас хойш 1 жилээс доошгүй байх
2. Гаалийн хяналтын бүсийн гэрэлтүүлэгтэй байх /БД 30-102-11 гудамж, талбайна гэрэлтүүлгийн нормд нийцсэн байх/
3. Гаалийн хяналтын бүсийн хамгаалалтын хашааны стандарт, бүрэн бүтэн байдал хангагдсан байх /гаалийн хяналтын бүс нь Монгол Улсын стандарт /MNS 5832:2007/-д нийцсэн байх/
4. Тухайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулах, болон байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх
5. Гаалийн талбайг гал түймэр, үер усны аюул гамшгаас хамгаалах шуурхай төлөвлөгөөг ирүүлэх
6. Тухайн үйл ажиллагаанаас үүссэн эрсдэлийг бууруулах зорилгоор хариуцлагын даатгалд хамрагдсан байх
7. Сүүлийн 2 жилийн байдлаар гаалийн байгууллагын зөрчлийн санд бүртгэгдээгүй байх /гашуунсухайт дахь гаалийн газрын тодорхойлолт ирүүлэх/
8. Нүүрс ачиж буулгах талбайд тоног төхөөрөмж ашиглах болон үйл ажиллагааг зохицуулах, хянах ХАБЭА-ын журамтай байх
9. Гаалийн хяналтын бүс нь Төвийн эрчим хүчинд холбогдсон буюу 50кВт дээш цахилгааны нөөц эх үүсвэртэй байх
10. Гаалийн хяналтын бүсийн гадна тайлбайд 30-с дээш нүүрс тээврийн автомашин зогсох зогсоолтой байх
11. Пүүний оператор, гаалийн бүрдүүлэлт, хяналт хийх ажилтныг байрлуулах ажлын байр нь 9м^2 дээш зөөврийн сууц эсхүл контэйнэр хаус байх /тэдгээрийн фото зургийг ирүүлэх/
12. Гаалийн хяналтын бүсийн ажилчдын ажиллаж, амьдрах зориулалт бүхий байр нь 180м2 дээш байх /оффис, гал тогоо, дүш, амралтын өрөө битүүмж дулаалга сайтай байх/

13. Гаалийн хяналтын бүсийн харуул хамгаалалтын байр нь 9м2 дээш байх
14. Хяналтын камер нь гаалийн хяналтын системд холбогдсон, камерын бичлэгийг 30-с дээш хоногийн хугацаанд хадгалах чадвартай байх
15. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам дагуу байрлалтай байх
16. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замруу шууд гарах гарцтай байх
17. Шинээр байгуулагдсан талбайн хувьд нүүрс буулгах талбайг урьдчилан бэлтгэсэн байх /ул дэвсэлт хийсэн байх/
18. Усны эх үүсвэр эсхүл нөөцийн байгууламжтай байх
19. Тээврийн хэрэгслийн хучлагын тавцантай байх
20. Гаалийн хяналтын бүсэд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт тоо хэмжээ, үзүүлэлтүүд: /Жич: техникийн бэлэн байдал 2023 оноос хойш үйлдвэрлэгдсэн, 500 мото/цагаас хэтрээгүй байх/
    - 3 метр куб багтаамжтай утгуурт ачигч 3 ширхэг ба түүнээс дээш
    - 5 метр куб багтаамжтай шанагатай утгуурт ачигч 3 ширхэг ба түүнээс дээш
    - 7 метр куб багтаамжтай шанагатай утгуурт ачигч 2 ширхэг ба түүнээс дээш
    - Чингэлэг ачиж буулгах зориулалт бүхий механикжсан төхөөрөмж 1 ба түүнээс дээш
    - 200-с дээш тоннын даацтай 2 ба түүнээс дээш 40м урттай авто жинтэй байх /стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулсан баталгаажуулалтын хуудсыг ирүүлэх/
    - Автомат ухаалаг орох, гарах гарцтай байх /давхар тээврийн хэрэгсэл орж гарахад саадгүй байх/
    - Талбайн усалгааны машинтай байх /20 тонноос дээш/
    - Түлшний машинтай байх /2 тонноос дээш/

Бүрдүүлэх материал:

1. Гаалийн хяналтын бүсийн дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн талаар дэлгэрэнгүй танилцуулга
2. Өмнөговь аймаг, Ханбогд сум, Хайрхан баг дах гаалийн хяналтын бүсийн байршлын бүдүүвч зураг
3. Засгийн газрын 2022 оны 10 сарын 25 өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой гаалийн хяналт, бүрдүүлэлтэд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө ирүүлэх
4. Барилга байгууламжийн дотоод зохион байгуулалт, өрөөний зай талбайн хэмжээ, ажлын байрны танилцуулга. Камер тус бүрээр харагдах орчинг фото зургаар баталгаажуулан ирүүлэх
5. Талбайн хүчин чадал, харуул хамгаалалт, камер, гэрэлтүүлгийн байршил, зохион байгуулалтын мэдээлэл ирүүлэх
6. Үл хөдлөх хөрөнгө болон газар эзэмших эрхийн гэрчилгээ ирүүлэх;
7. Гаалийн талбайг гал түймэр, үер усны аюул гамшгаас хамгаалах шуурхай төлөвлөгөөг ирүүлэх
8. Тухайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулах, болон байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх

Боловсруулсан:
Борлуулалт, тээвэр ложистикийн хэлтсийн захирал Н.Үнэнбодрол